

СОЁМБО МЭДЭЭ

"СОЁМБО" РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.03.15 №08 (08)

Өнөөдөр

"ХАРАНГА" ХАМТЛАГЫНХНЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАНА

Тус өдөр Монгол Улсын Засгийн газрын гишүүн Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр "Харанга" хамтлагийн уран бүтээлчдийг хүлээн авч уулзана. Тэд Зэвсэгт хүчний 100 жилийн ойн хүрээнд хамтран ажиллах ажлын талаар ярилцахаас гадна Батлан хамгаалахын сайд хамтлагийн уран бүтээлчдэд салбарын шагнал гардуулах аж.

"ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРЭГ НЭГЭН ЗУУНД"

Зэвсэгт хүчний хуурай замын цэргийн командлал, УБХИС, БХЭШХ хамтран "Хуурай замын цэрэг нэгэн зуунд" сэдэвт эрдэн шинжилгээний хурлыг цахимаар зохион байгуулна. Тус хуралд "Монгол Улсын Зэвсэгт хүчний хуурай замын цэргийн түүхэн хөгжил, одоо ба ирээдүй", "Хуурай замын цэргийн байлдааны дэмжлэг, хангалтыг зохион байгуулж ирсэн туршлага, сургаж, хөгжлийн чиг хандлага", "Хуурай замын цэргийн удирдлагыг оновчтой төгөлдөржүүлэн хөгжүүлэхэд баримталсан бодлого, түүний чиг хандлага" зэрэг 10 гаруй үндсэн болон хавсралт илтгэл хэлэлцэх ажээ.

Маргааш

НИЙСЛЭЛ ХОТЫН УДИРДЛАГА БХЯ, ЗХЖШ-ЫН УДИРДАХ БҮРЭЛДЭХҮҮНТЭЙ УУЛЗАНА

"Монгол цэргийн өдөр", Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулж Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар БХЯ, ЗХЖШ-ын удирдлагыг хүлээн авч хүндэтгэл үзүүлнэ.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 353 ДУГААР АНГИ НЭРЭМЖИТ БОЛНО

Зэвсэгт хүчний 353 дугаар ангийг дэслэгч генерал Ч.Пүрэвдоржийн нэрэмжит болгох ёслолын арга хэмжээ болно. Тус арга хэмжээнд Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч, бригадын генерал О.Энхбаяр болон дэслэгч генерал Ч.Пүрэвдоржийн аргын төлөөлөл, албаны бусад хүмүүс оролцох юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-5°C	-8°C

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
41°C	28°C

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
12°C	1°C

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,845.0	2,858.0
EUR	3,351.0	3,416.0
CNY	433.20	438.00
RUB	37.49	39.21
JPY	25.85	26.49
KRW	2.44	2.56

КОВИД-19 МЭДЭЭ

ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН	128
НИЙТ БҮРТГЭГДСЭН	3961
ЭДГЭРСЭН	3001
НАС БАРСАН	8

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

ШИНЭЭР НЭМЭГДСЭН	57
ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	250
ЭДГЭРСЭН	905

ӨРНИЙН ЗУРХАЙ

2021.03.15 /ДАВАА ГАРАГ/

ХАВРЫН ДУНД ЦАГААГЧИН ТУУЛАЙ САРЫН ЗУРГААН ЦАГААН ХАР НОХОЙ ӨДӨР

Үс засуулвал:
Хэл, ам, хэрүүл тэмцэл ирнэ

Наран ургах, шингэх:
07.05-18.57

Барилдлага: Рашаан

Шүтэн барилдлага: Нэр өнгө

Суудал: Төмөр

Аргын тооллын 3 сарын 15, Сумъяа гараг. Билгийн тооллын 2, Дэлгэрүүлэгч одтой, хар нохой өдөр. Өдрийн наран 7 цаг 05 минутад мандан, 18 цаг 57 минутад жаргана. Тухайн өдөр бар, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн. Эл өдөр эм, эмнэлгийн үйл, хагалгаа хийлгэх, биеийн тамирыг сэргээх, угаал үйлдэх, хүүхэд үрчлэн авах, андгай тангараг, гэрээ, хэлцлээ буцаахад сайн. Нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийх, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсоод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Модон хохимой өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ҮЙЛ ЯВДАЛ

ГЕНЕРАЛУУДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ БАЙГУУЛЛАА



Монгол Улсын Батлан хамгаалах бодлого, зорилт, цэргийн шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэх, Орчин цагийн Зэвсэгт хүчнийг хөгжүүлэхэд өөрийн оюун ухаан, хөдөлмөр зүтгэлээ зориулж, үнэтэй хувь нэмэр оруулсанд нь талархаж чөлөөнд байгаа хошууч генерал Г.Махбариад, Ч.Улаанхүү нарт орон сууц худалдан авахад нь зориулж мөнгөн дэмжлэг үзүүлснийг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр өнөөдөр гардуулан өглөө.

Энэ нь Батлан хамгаалах сайдын 2020 онд батлагдсан "Бэлтгэл болон чөлөөнд байгаа Монгол Улсын генерал цолтонд орон сууц, түүний үнийн дүнтэй дүйцэхүйц хэмжээний мөнгөн дэмжлэг үзүүлэх журам"-ын хүрээнд олгож байгаа юм. Чөлөөнд байгаа хошууч генерал Г.Махбариад, Ч.Улаанхүү нар Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жил, "Монгол цэргийн өдөр"-ийн босгон дээр ийнхүү хүлээн авч, хүндэтгэл үзүүлж, нийгмийн асуудалд нь бодит дэмжлэг үзүүлж буйд баярласнаа илэрхийлээд баярын мэнд дэвшүүлээ.



Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр энэ сарын 11-ний өдөр Төрийн ордонд нийслэл болон аймгуудын Засаг дарга нартай 2021 онд хамтран ажиллах гэрээг байгуулла. Энэ удаагийн хамтран ажиллах гэрээнд улсын Батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах зориулалтаар

цаашид амжилттай хамтран ажиллах, "Хүүхэд, залууст эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг үе шаттай хэрэгжүүлэх, цэргийн насны болон өсвөр үеийнхэнд цэргээ эх оронч хүмүүжлийг олгоход чиглэсэн гурваас доошгүй ажлыг зохион байгуулах зэрэг хэд хэдэн заалт тусгагджээ.

СЭТГҮҮЛЧИД ЦЭРГИЙН БЭЛТГЭЛ СУРГАЛТАД ХАМРАГДАВ



Батлан хамгаалах яам үүсэн байгуулагдсаны 110, Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд зохион Хэвлэл мэдээллийн ажилтнуудтай цэргийн бэлтгэл сургалтыг энэ сарын 13-нд зохион байгууллаа. Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр энэ үеэр хэлэхдээ, "Манай яам хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлч сурвалжлагчидтай нягт харилцаатай байж, ирэх жилүүдэд нээлттэйгээр ажиллах болно. Батлан хамгаалах салбар цаашид иргэндээ ойр,

улс орны хөгжилд өндөр хувь оролцоотой салбар байх юм. Өөрөөр хэлбэл, "Цэргийг 1000 өдөр тэжээж, нэг өдөр хэрэглэнэ" гэсэн үзэл баримтлалтай байж болохгүй. Тус салбар өмнө нь төрлийн цэргийн хоёр командлалтай байсан бол Тусгай хүчний цэргийн командлал, Кибер аюулгүй байдлын цэргийн командлал, Барилга-Инженерийн цэргийн удирдах газар гэсэн гурван шинэ командлалыг байгууллаа. Тухайлбал, Барилгын цэрэг гэхэд улс орныхоо хөгжлийн төлөө ажиллах хэдий ч нөгөөтэйгөөр тэдний барьсан

бүтээн байгуулалт, зам гүүр оролцоотой эрх ашигт нийцдэг байх тухайд анхаарч ажиллаж байна. Мөн цэрэг, Зэвсэгт хүчин нь улс төрөөс ангид, авлига, хээл хахуулиас хол, хамгийн дэг журам, сахилга баттай салбар байх хуульд заасан үүргээ биелүүлж ажиллана" гэлээ. Сургалтад нийт 30-аад сэтгүүлч, сурвалжлагч хамрагдсан бөгөөд БХЯ, ЗХЖШ-ын газар, хэлтсийн дарга нар тус яамны үүсэл хөгжил, хууль эрх зүйн шинэтгэл, өнөөгийн нөхцөл байдал, цаашид хийхээр төлөвлөж буй бүтээн байгуулалтын ажил, дэлхийн

хөгжлийн чиг хандлага болон түүхэн ойн хүрээнд зохиогдох томоохон ажлуудын талаар товч мэдээлэл өглөө. Үүний дараа оролцогчид Хужирбулан дахь сургалтын төвд зочилж, төвийн үйл ажиллагаатай танилцсан юм. Мөн Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн танилцуулга, Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчинд шинээр нэвтрүүлж байгаа зэвсэглэл техниктэй танилцаж, гардан тулааны үзүүлэх сургууль үзэж сонирхов. Сургалтын төгсгөлд сайд, бригадын генерал Г.Сайханбаяр оролцогчдод гэрчилгээ гардуулж, ажлын амжилт хүслээ.



ЗЭВСЭГТ ХҮЧИН-100

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТҮҮХ, ШИНЭЧЛЭЛ, ХӨГЖЛИЙН ТАЛААРХ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ БОЛОВ



Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Үндэсний батлан хамгаалахын их сургууль хамтран "Монгол Улсын Зэвсэгт хүчний нэгэн зууны түүхэн хөгжил: 1921-2021 он" сэдэвт эрдэм шинжилгээний онол, арга зүйн хурлыг 3 дугаар сарын 12-ны өдөр цахимаар зохион байгууллаа. Тус хурлын зорилго нь Орчин

цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн түүхэн хөгжил, ололт, амжилтыг дүгнэн, Монгол Улсын Зэвсэгт хүчний өмнө тулгамдаж буй асуудлаар удирдлагын болон эрдэм шинжилгээний байгууллагууд санал солилцож, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг цэргийн шинжлэх ухааны үндэслэлтэй явуулж онол, практикт нэвтрүүлэхэд хамтран ажиллах, нэгдсэн ойлголтот хүрэхэд чиглэгдсэн юм. Хуралд Засгийн газрын

гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Батлан хамгаалахын дэд сайд, Батлан хамгаалах яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн дарга Б.Баярмагнай, ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг, Шинжлэх ухааны академийн тэргүүн дэд ерөнхийлөгч, академич Б.Авид болон БХЯ, ЗХЖШ, ХЗЦК, АЦК, ҮБХИС, БХЭШХ-ийн удирдлага, эрдэмтэн судлаачид, "Монгол цэргийн нэгдсэн

холбоо"-ны Ерөнхий нарийн бичгийн дарга, доктор (Ph.D), профессор, бэлтгэл дэслэгч генерал Ц.Тогоо, "Монгол генерал төв"-ийн тэргүүн, доктор (Ph.D), профессор, бэлтгэл хошууч генерал С.Баасанхүү нар оролцсон юм. Хурлын ажиллагааг нээж Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай хэлсэн үгэндээ БХЯ-ны ШУТЗ-өөс Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан 9 дэд зорилт, 48 арга хэмжээний хүрээнд бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байгааг онцлон дурдаж, хурлын үйл ажиллагаанд өндөр амжилт хүслээ. Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчний төлөвшүүлэх, үүрэг гүйцэтгэх бэлэн байдал, цэргийн алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, гадаад улс орнуудтай цэргийн итгэлцэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх, цэргийн алба, сахилга, зохион байгуулалтыг өндөржүүлж, албаны ухамсрыг дээшлүүлэх зорилго, зорилтуудыг ханган биелүүлэхэд Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний удирдлага, бие бүрэлдэхүүний хамтын хүчин чармайлт, идэвх санаачилга нэн чухал гэдгийг тодотгоод удахгүй болох Орчин цагийн Зэвсэгт хүчний 100

жилийн ойн баярын мэндийг хүргэв.

Эрдэм шинжилгээний хурлын үдсэн илтгэлийг "Монгол Улсын Зэвсэгт хүчний нэгэн зууны түүхэн хөгжлийн замнал, өнөө ба ирээдүй" сэдвээр ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг илтгэсэн бөгөөд тэрээр тус илтгэлийг БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, доктор, профессор, Ш.Паламдоржтой хамтран бэлтгэж, хэлэлцүүлсэн юм. Түүнчлэн "Төрлийн цэргийг хөгжүүлэх бодлого, хэрэгцээ, шаардлага", "Зэвсэгт хүчний сургалтын тогтолцоог шинэчлэх арга зам", Энхийг дэмжих ажиллагаа дахь Монгол цэргийн оролцоо Зэвсэгт хүчний хөгжлийн нэгэн тулгуур болох нь", "БНМАУ-ын хөгжилд Барилгын цэргийн оруулсан хувь нэмэр, Монгол Улсын стратегийн бүтээн байгуулалтад Барилга-Инженерийн цэргийн оролцоо, цаашдын хандлага, "Зэвсэгт хүчний түүхэн хөгжил-Монголын Ардын Армийг өргөтгөн зохион байгуулсан нь", "Зэвсэгт хүчний хөгжил дэх цэргийн алба хаагчдын манлайлал, түүнд хийсэн шинжилгээ" зэрэг Зэвсэгт хүчний хөгжил шинэчлэл, сургалт бэлтгэлийн тогтолцоог цаашид боловсронгуй болгохтой холбоотой олон чухал сэдвээр хэлэлцүүлжээ. Холтой 10 гаруй хавсралт илтгэлүүдийг хэлэлцүүлжээ.

ҮЙЛ ЯВДАЛ

ШИЛДГҮҮДЭД ШАГНАЛЫГ НЬ ГАРДУУЛАВ



Орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тохиолдуулан Зэвсэгт хүчний Жанжин штабаас Батлан хамгаалах яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабуудтай хамтран оюутан, сурагчдын дунд "Монгол Улсын Зэвсэгт хүчин-100" сэдэвт гар зургийн уралдааныг оюутан, сурагчдын дунд зохион байгуулсан билээ. Хоёр сарын хугацаанд явагдсан тус уралдаанд нийслэлийн есөн дүүрэг, 21 аймгаас 800 гаруй оюутан, сурагчид бүтээлээ ирүүлсэн юм.

Шилдэг 50 бүтээлийн үзэсгэлэн болон шагналт байруудад шалгарсан оюутан,

сурагчдад шагнал гардуулах ёслол өнгөрсөн Бямба гарагт Монгол цэргийн музейд боллоо. Шагнал гардуулах ёслолд Зэвсэгт хүчний Жанжин штабын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг, Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа Ц.Анхбаяр, ЦДБЭЧ-ийн дарга, Соёлын төв өргөөний ерөнхий менежер хурандаа Г.Золзаяа тэргүүтэй албаны хүмүүс оролцож, бүтээл нь шалгарсан оюутан, сурагчдад баяр хүргэсэн юм. Шалгарсан оюутан, сурагчдад өргөмжлөл, мөнгөн шагнал болон хэвлэлтээс гараад удаагүй байгаа "Монгол Улсын Зэвсэгт хүчин-100" гэрэл

ЦАХИМ ШУУДАНД

ХОШУУЧ ГЕНЕРАЛ Г.ТҮМЭЭГИЙН НЭРЭМЖИТ ШАГНАЛ ХҮРТЭЭВ

ЦЕС-ийн Артиллерийн ангийг 1940 онд, ЗХУ-д Артиллерийн академийг 1948 онд төгсөж, ЦЕС-ийн их бууны секцийн дарга, АЦЖШ-ын их бууны командлагч, ЦЕС-ийн захирал зэрэг ажлуудыг хийж байсан артиллерчин хошууч генерал Г. Түмээгийн үр хүүхдүүд аавынхаа "Нэрэмжит шагнал" -ыг бий болгож жил болгон ҮБХИС, ЦНДС-ийн Артиллер-Зэвсгийн

тэнхимийн шилдэг нэг багш, сонсогчийг шалгаруулан шагнадаг юм.

2020 оны шилдэг багшаар Артиллер-Зэвсгийн тэнхимийн тагнуул байр зүйн багш ахмад С.Лхагважавыг шалгаруулжээ. Генерал С.Түмээгийн хүү Т.Жаал-Алдар МАЦХ-ны ажлын байранд нэрэмжит шагналыг ахмад С.Лхагважавт гардуулан өглөө. Шагнал гардуулахад МАЦХ-ны дэд

тэргүүн хурандаа Н.Доржханд, гүйцэтгэх захирал хурандаа Ж.Ванчинсүрэн, удирдах зөвлөлийн гишүүн хурандаа Д.Гантулга, ЦНДС-ийн Артиллер-Зэвсгийн тэнхимийн дарга Ц.Цэрэнбат нар байлцлаа. Г.Түмээ агсаны үр хүүхдүүд Артиллерийн цэргийн болон Артиллерийн цэргийн мэргэжилтэн бэлтгэж эхэлсний 100 жилийн ойд бэлтгэх ажилд амжилт хүслээ.

ИХ ГОВИЙН ГАРНИЗОНЫ АВАРГУУД ТОДОРЛОО

336 дугаар анги

Зэвсэгт хүчний 100 жилийн ой, "Монгол цэргийн өдөр"-ийг угтан ангийн марш тактик-тусгай бэлтгэлийн аварга шалгаруулах тэмцээнийг 2021 оны 3 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд явууллаа. Тэмцээний зорилго нь Зэвсэгт хүчний марш тактик-тусгай бэлтгэлийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэл, цэргийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх замаар хуулиар хүлээсэн үндсэн болон тайван цагт гүйцэтгэх үүргээ биелүүлэх чадварыг нэмэгдүүлэхэд оршиж байгаа юм. Марш-тусгай бэлтгэлийн аварга тасгаар ахлах ахлагч Э.Буянбаатар, хошууч А.Батбаатар, ахмад Ж.Пүрэв-Очир захирагчтай тасгууд, аварга



салаагаар дэслэгч Н.Гэрэлт-Ирээдүй, дэслэгч М.Сатжан, дэслэгч Э.Шинэбаяр захирагчтай салаа шалгарсан бол мэргэжлийн аварга

эмэгтэй цэргийн алба хаагчаар ахмад Д.Жаргалсайхан, ахлагч П.Энхмаа, дэслэгч Ч.Бодьгэрэл нар тодорлоо.

Дэслэгч Ч.БОДЬГЭРЭЛ

АЛБА ХААГЧДЫНХАА ОНОЛ, ДАДЛАГЫГ БАТАТГАЛАА

167 дугаар анги

Салаа хоногийн болоод тактикийн хээрийн сургуулийг тус тус зохион байгууллаа. Төлөвлөгөөт хоногийн сургуулийг салааны жигдрэлтийг хангах хүрээнд явуулсан бол тактикийн хээрийн

сургуулийг говь хээрийн нөхцөлд давших, байлдааны ажиллагаа зохион байгуулж явуулах, байлдааны явцад салаа, салбаруудыг гал удирдах сөрөг давшилт, мөрдөн хөөх ажиллагааны онол, дадлагаар олж авсан мэдлэгийг

нь батжуулах зорилгоор явуулсан юм. Сургуулиудыг ангийн Говийн бүсийн сургалтын төвд явуулсан бөгөөд бие бүрэлдэхүүний мэдлэг, ур чадвар, дадлагыг нэмэгдүүлсэн ач холбогдолтой боллоо.

Ахмад Ё.БАТ-ЭРДЭНЭ



СОЁМБО СОНИН

"Соёмбо" сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,
Д.НАЦАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор
Хурандаа
САНЖМЯТАВЫН
ТӨМӨРХУЯГ

Эхийг "Соёмбо"
сонини редакцал
бэлтгэв.

*Зар, рекламьг хямд нийтэлнэ.
*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл болон сонини нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонини мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018

И-мэйл хаяг:
Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029